БАТЛАВ.
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ПҮРЭВХАТАН

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ

- **Тээврийн хэрэгслийн тоо:** 12 автомашин
- **Даатгуулах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.
  - Нэмэлтээр 2 ширхэг тээврийн хэрэгслийн даатгалыг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл даатгуулна.
- **Тээврийн хэрэгслийн нийт үнэлгээ: 1,540,690,909.00** (нэг тэрбум таван зуун дөчин сая зургаан зуун ерэн мянга есөн зуун ес) төгрөг.

№	Даатгуулагчаас тогтоосон тээврийн хэрэгслийн даатгалын эрсдэлүүд	Нөхөн төлбөр төлөх хувь, хэмжээ
1	Зам тээврийн хөдөлгөөний үеийн бүх төрлийн осол	100%
2	Замын хөдөлгөөнд оролцох үед бусад этгээд мөргөөд зугтсан үеийн эрсдэл	
3	Биет зүйл автомашин дээрээс унах эрсдэл	
4	Гуравдагч этгээдийн санаандгүй үйлдлийн улмаас учирсан хохирол	
5	Тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд ороогүй буюу засвар үйлчилгээ, угаалгын газар, гарааш талбай, гадаа зогсоолд тавьсан ба байршуулах үеийн бүх эрсдэл	
6	Хулгай, дээрэм түүний үр дагаврааас шалтгаалан даатгалын зүйлд учирсан хохирол	
7	Галын бүх төрлийн гал түймэр, тэсрэлт, дэлбэрэлт, шаталт	
8	Албан үүрэг гүйцэтгэж байх үед баталгаат бус замаар зорчих үеийн эрсдэл	
9	Байгалийн бүх төрлийн эрсдэл	
10	Хөрсний нуралт, цөмрөлт	
11	Замын хөдөлгөөнд оролцсон болон оролцоогүй үеийн шилний эрсдэл	
12	Жолоо шилжүүлсэн үеийн эрсдэл	
13	Бүрэн хулгайн эрсдэл	
14	Авто машины дугуйн эрсдэл	
15	Улаанбаатар хот дотор ослын газраас өөрөө явах боломжгүй болсон авто тээврийн хэрэгслийг засварын газар хүртэл үнэ төлбөргүй тээвэрлэх	Нэг авто машиныг 1 удаа
16	Авто машины хохирлын үнэлгээний зардал	100%

17	Даатгуулагчийн буруутай үйлдлээс учирсан хохирлыг даатгуулагч хариуцах хувь	10%

2. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

- **Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах тээврийн хэрэгслийн тоо:** 14 автомашин
- **Даатгуулах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.

№	Даатгуулагчаас тогтоосон тээврийн хэрэгслийн даатгалын эрсдэлүүд	Нөхөн төлбөр төлөх хувь
1	Бусдын амь насанд учруулсан хохирол	100%
2	Бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол	
3	Бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол	

3. АМЬ НАС, ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ

Зорилго: Хөдөлмөрийн гэрээ болон Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж буй ажилтан, Монгол улсын нутаг дэвсгэр болон дэлхийн бусад оронд томилолтоор ажиллах, аялах үед ажилтны амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, мэргэжлээс шалтгаалах өвчин, ердийн болон халдварт өвчин, бүх төрлийн архаг өвчин, жирэмслэлтийн үеийн хүндрэл, бүх төрлийн гэнэтийн ослоос үүдэн хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдах, эмчилгээний зардал гарсан тохиолдлыг даатгалын компаниар нөхөн төлүүлэх замаар ажилтныг ирээдүйд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зорилготой.

- **Даатгуулагчийн тоо:** 150 ажилтан
- **Даатгуулах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс хойш 12 сар.

Ажилчдын амь нас, гэнэтийн ослын даатгалд тавигдах нөхцөл:

- Даатгуулагч нь нас барсан (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.4-т заасны дагуу) болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд үнэлгээг 100 хувиар, хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тооцож олгоно.

№	Ангилал	Эрсдэлийн нөхцөлүүд	Нөхөн төлбөр төлөх хувь
1	Ахуйн болон албаны	Унаснаас үүдсэн бэртэл, гэмтэл	100%
2		Зам тээврийн аюул осолд өртөх	
3		Элдэв зүйлст цохигдох, хавчигдах	
4		Түлэгдэх, халтирах	
5		Хөлдөх, осгох	
6		Зүсэгдэх, хугарах	
7		Наранд цохиулах	
8		Угаартах	

9		Хорт хийнд хордох	
10		Уралдаан тэмцээний үед бэртэх гэмтэх, цус алдах	
11	Хордлогод орох	Нарны	100%
12		Хоолны	
13		Химийн	
14		Цочмог үрэвслийн	
15		Эмийн болон ургамлын	
16	Байгалийн бүх төрлийн эрсдэл	Газар хөдлөлт	100%
17		Хүчит салхи	
18		Цасан болон шороон шуурга	
19		Үер усны аюул	
20		Хөрсний болон уурхайн нуралт, цөмрөлт	
21		Замын эвдрэл, гэмтэл, нуралт	
22		Аянга, аадар бороо, мөндөр	
23		Гал түймэр	
24		Усанд живэх	
25		Шавар, намагт шигдэх	
26	Үйлдвэрлэл, техникийн эрсдэл	Машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үеийн эрсдэл	100%
27		Цахилгаан хүчдэлд цохиулах	
28		Дэлбэрэлт, шаталт зэргийн нөлөөгөөр учирсан хохирол	
29		Сантехник дулааны сүлжээний гэмтлийн гарч болох эрсдэл	
30		Унадаг дугуй, мотоцикл, автомашин зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл осолдох, мөргөлдөх, унах, живэх	
31	Мал, амьтны халдлагад өртөх эрсдэл	Хазуулах, уруулах	100%
32		Мөргүүлэх	
33		Чирэгдэх	
34		Малд дайруулах	

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

- **Даатгуулагчийн тоо:** 150 ажилтан
- **Даатгуулах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.

№	Даатгуулагчийн хамгаалалт	Хамгаалалтын хязгаар
Хамгаалалтын дээд хэмжээ		300,000 төгрөг
1	Хамгаалалтын дээд хэмжээ хүртэл магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн амбулатори, багцын оношилгоо шинжилгээнд гэрээний хугацаанд 1 удаа хамруулах	100%

5. МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

- **Даатгуулагчийн тоо:** 50 ажилтан
- **Даатгуулах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал.

Мэргэжлийн хариуцлагын даатгалд тавигдах нөхцөл:

- **Даатгуулагчийн төрөл**: Инженер, техникийн ажилтан
- **Ерөнхий шаардлага:** Ажил үүргээ гүйцэтгэх үедээ мэргэжлийн алдаа, санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас үйлчлүүлэгчид учирсан эрсдэлийг хамгаалах.

№	Эрсдэл	Нөхөн төлбөр төлөх хувь
1	Ажилтны эрсдэл (Даатгуулагчийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас учрах хохирол)	100%
2	Эд хөрөнгийн эрсдэл (Даатгуулагчийн эд хөрөнгийн ашиглалтын үед үүсэх хохирол)	100%
3	Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл (Даатгуулагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний улмаас учрах хохирол)	100%
4	Бохирдлын хариуцлага (Даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой бохирдуулагч бодисоос үүдэн гарсан хохирол ба уг бохирдуулагч бодисыг цэвэрлэх, зайлуулахтай холбоотой зардал)	100%

Бусад шаардлага:

1. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн мэдээлэл, хувь хүний мэдээллийг зөвхөн шалгарсан гүйцэтгэгчид олгох;
2. Даатгагч нь даатгалын нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 19.2, 19.3-д заасан хугацаанд багтаан шийдвэрлэх;
3. Даатгалын нөхөн төлбөрийг ажилтанд нөхөн төлөхөд ажлын 10 хоногт, эмнэлгийн байгууллагад зардлыг шилжүүлэх тохиолдолд ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэх;
4. Даатгагч нь даатгалын тохиолдол гарах үед авах арга хэмжээний талаар сургалтыг өөрийн зардлаар гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 21 хоногийн дотор багтаан 2 удаа явуулах;
5. Даатгуулагч нь гэрээ хэрэгжих хугацаанд заасан нөхцөлөөр давтан нөхөн төлбөр нэхэмжилж болох бөгөөд хэмжээ нь даатгалын үнэлгээ, хязгаараас хэтрэхгүй байх;
6. 2 тал гэрээнд шинээр нэмэгдэх, хасагдах ажилчдыг тухай бүр бүртгэж, хагас жил тутам гэрээ дүгнэсэн акт үйлдэж, хамтран ажиллах;
7. Ажилтан нэмэх, хасах тохиолдолд тухайн нэмэгдсэн өдрөөс эхлэн гэрээний дуусах хугацаа хүртэлх хураамжийг (даатгалын жилийн хураамж /365×даатгах хугацаагаар) тооцож, гүйцэтгэлээр хураамжийг шилжүүлэх;

8. Тээврийн хэрэгсэл болон даатгуулагчийн мэдээллийг илгээхдээ бичвэр, алдаа гарсан тохиолдолд шимтгэл, хураамжгүйгээр 2 тал залруулга хийнэ.

Хянасан:
Захиргаа, аж ахуйн хэлтсийн дарга Т.Баасанцогт

Боловсруулсан:
Хүний нөөцийн асуудал хариуцсан
Ахлах мэргэжилтэн С.Ганцэцэг